

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ОРШИЛ.....	3
БҮЛЭГ 2.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	4
2.1.Төлөвлөгөөний нэр.....	4
2.2.Төсөл хэрэгжүүлэгч байгууллага.....	4
2.3.Төслийн зорилго.....	4
2.4.Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга.....	4
2.5.Төслийн байршил.....	4
2.6.Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	5
2.7.Төслийн үйлдвэрлэлийн нөөц.....	5
2.8.Ил уурхайн ашиглалтын технологи.....	5
2.9.Ил уурхайн хэмжээ, хэмжээсүүд.....	6
2.10.Төслийн хүчин чадал.....	6
2.11.Уурхайн ажиллах горим.....	6
2.12.Уулын ажлын төлөвлөлт.....	7
2.13.Хөрс хуулалтын ажил.....	7
2.14.Тоног төхөөрөмжүүд.....	7
2.15.Ангилан ялгах технологи.....	7
2.16.Гарган авах бүтээгдэхүүн, орлого, зардал.....	8
2.17.Усан хангамж.....	8
2.18.Ил уурхайн барилга байгууламжууд.....	8
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	9
3.1. Байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт.....	9
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	11
4.1.Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	11
БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	13
БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
6.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	16
6.3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
6.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	17
6.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
6.6.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
6.7.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	19
6.8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
6.9.Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	21
6.10.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	22
6.11.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	23
ДҮГНЭЛТ.....	24
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ.....	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Компаний мэдээлэл.....	4
Хүснэгт 2. Уурхайн талбайн солбилцол.....	4
Хүснэгт 3. Ил уурхайн зохиомжлолд тусгасан үзүүлэлтийн хэмжээс	6
Хүснэгт 4. Уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд.....	7
Хүснэгт 5. Барилга, байгууламжийн мэдээлэл	8
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	21
Хүснэгт 12. БОМТ-ийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	22
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	23

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг	5
Зураг 2. Бутлан ангилах хэсгийн тоног төхөөрөмжийн холболтын схем.....	8

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь хэрэгжиж буй уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “СҮХЖИН” ХХК-иас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

“СҮХЖИН” ХХК-ийн элс-хайрганы холимгийн ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29–ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу боловсрууллаа.

“СҮХЖИН” ХХК-ийн 2026 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Жил бүрийн БОМТ-ий биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11-р сарын 01-ны дотор БОАЖЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

“СҮХЖИН” ХХК нь 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 31-р зүйлд заасны дагуу БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

БҮЛЭГ 2.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2.1.Төлөвлөгөөний нэр

“Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2.2.Төсөл хэрэгжүүлэгч байгууллага

“Сүхжин” ХХК

2.3.Төслийн зорилго

“Чойбалсан-1” ордын элс-хайрганы холимгийг олборлож зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

2.4.Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

Хүснэгт 1. Компаний мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Сүхжин” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		0711001032
3	Уурхайн нэр		“Чойбалсан-1”
4	Ордын нэр		“Чойбалсан-1”
5	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Дорнод
6		Сум/Дүүрэг	Хэрлэн
7	Ашигт малтмалын төрөл		Элс-хайрганы холимог
8	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		ДО-001А
9	Ашиглалт эхэлсэн огноо		-
10	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Дорнод
11		Сум/Дүүрэг	Хэрлэн
12		Баг/Хороо	6-р баг
13		Гудамж/Байр	1-тоот
14		Утас	976-70582092
15		Гар утас	976-99529549
16		Электрон шуудан	Suhjin.goltd@gmail.com
17		Захирлын хаяг	Нэр
18	Гар утас		99992068


2.5.Төслийн байршил

“Чойбалсан-1” элс-хайрганы орд нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутагт харьяалагдах бөгөөд аймгийн төвөөс 2.5 км зайд Хэрлэн голын урд талд голын хөвөөнөөс 1.2 км-ийн хол 1-р дэнжийн ойролцоо байрладаг. Нийт 59.2 га талбайтай.

Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж буй талбайн захын цэгүүдийн солбицол:

Хүснэгт 2. Уурхайн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1.	114° 33' 02.00"	48° 02' 03.00"
2.	114° 33' 02.00"	48° 02' 36.00"
3.	114° 33' 30.00"	48° 02' 36.00"
4.	114° 33' 30.00"	48° 02' 03.00"



Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг

2.6.Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Чойбалсан-1” нэртэй 59.2 га талбай бүхий ашигт малтмалын DO-001A дугаартай тусгай зөвшөөрлийг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдөр “Сүхжин” ХХК-д олгосон байна.

2.7.Төслийн үйлдвэрлэлийн нөөц

“Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын нөөц нь Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 тушаалын хавсралтын дагуу I бүлгийн орд бөгөөд хайгуулын ажлаар тогтоогдсон геологийн бодитой (B) нөөцөд тулгуурлан ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байна.

Уурхайн хил хязгаар дотор орших хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг тооцоходоо Геологийн бодитой (B) зэрэглэлийн нөөцийг магадласан (B') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн тооцоолов. Ордын магадласан (B') үйлдвэрлэлийн нөөцөөр 2,137.43 мян.м³ элс-хайрганы холимог олборлоно. Нийт 265.32 мян.м³ хөрс хуулах ба хөрс хуулалтын дундаж коэффициент 0.12 м³/м³ байна.

2.8.Ил уурхайн ашиглалтын технологи

Уул-техникийн нөхцөл: Орд газар нь Чойбалсан хотын төвөөс чанх урагшаа Хэрлэн голын хөндийд 1-р дэнжийн тохойрсон хаяа хэсгээр оршдог. Хайгуулын ажлын малталтаар 23

малталанд хөрсний 4.3-4.5 метрт ус илэрсэн. Ордын геологийн тогтоц нь энгийн тогтоцтой орд юм. Хөрсний дундаж зузаан 0.5 м, элс-хайрганы дундаж зузаан 4.93 м байна. Ордын элс-хайрганы холимгийн болон хөрсний зузаан, блокийн урт, өргөн зэрэг үндсэн үзүүлэлтүүд нь харьцангуй жигд тогтвортой үргэлжилдэг уурхайн олборлолт, ашиглалтын явцад ямар нэг хүндрэл байхгүй үйлдвэрлэлийн жигд ажиллагааг хангах сайн талтай.

Уурхайн нээлт: “Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын нээлтийг ерөнхий траншейгаар В-3 блокоос уулын ажлыг эхлэн явуулна.

Ашиглалтын систем: Ордыг ил аргаар гадаад, дотоод овоолго бүхий авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглаар ашиглахаар сонгов.

2.9. Ил уурхайн хэмжээ, хэмжээсүүд

Уурхайн хэмжээ: Уурхайн оновчтой хүрээ, хязгаарыг тооцож нөөцийг бүрэн дүүрэн ашиглахад магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцийн дагуу 2,137.43 мян.м³ элс-хайрганы холимог олборлохоор байна.

Мөн В-3 нөөцийн зарим хэсэг уурхайн доголыг үүсгэхэд лицензийн хүрээнд тулж байгаа учраас уурхайн гадна хаягдах нөөцийн хэмжээ 0.18 мян.м³ байна.

Уурхайн эцсийн байдлаар ашиглаж дуусахад дунджаар 790м х 540м харьцаа бүхий ухаш үүснэ.

Ил уурхайн хэмжээсүүд: Ил аргаар олборлох ашиглалтын хувилбарыг сонгож ил уурхайн үндсэн хэмжээсүүдийг сонголоо.

Хүснэгт 3. Ил уурхайн зохиомжлолд тусгасан үзүүлэлтийн хэмжээс

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээс
1	Ил уурхайн ажлын доголын өндөр	м	2.7
2	Ил уурхайн ажлын бус доголын өндөр	м	5.5
3	Доголын хажуугийн өнцөг	град	65
4	Траншейн өргөн	м	10
5	Траншейн налуу	%	80

2.10. Төслийн хүчин чадал

“Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын ил уурхайн хүчин чадлыг захиалагч компанийн саналыг үндэслэн хүчин чадлыг жилд 26.0 мян.м³ элс-хайрганы холимог олборлохоор техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан байна.

“Чойбалсан-1” элс хайрганы холимгийн уурхайгаас 2022 онд 26.0 мян.м³ элс хайрганы холимог олборлон борлуулна.

2.11. Уурхайн ажиллах горим

Уурхай нь 04 дүгээр сарын 15-наас 09 дүгээр сарын 15-ны хооронд тасралтгүй ажиллах бөгөөд 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна. 2024 онд нийт 126 хоног ажиллана.

2.12. Уулын ажлын төлөвлөлт

Уулын ажлыг төсөл захиалагч “Сүхжин” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу 04 дүгээр сарын 15-наас эхлэхээр төлөвлөсөн бөгөөд төсөл захиалагчийнн техникийн даалгаврын дагуу ордыг 81 жил ашиглахаар төлөвлөсөн байна.

Уурхайн ашиглалтын 81 жилийн хугацаанд нийт 265,32 мян.м³ хөрс хуулж 2402,75 мян.м³ элс-хайрганы холимгийг олборлоно. Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр 0.12 м³/м³ байна.

2.13. Хөрс хуулалтын ажил

Шимт хөрс. Шимт хөрсийг утгуурт ачигчаар хуулж, автосамосвалд ачин, тээвэрлэн шимт хөрсний түр овоолго үүсгэнэ. Шимт хөрсийг уурхай, бусад талбайгаас 0.2 метрийн зузаантайгаар хуулна. Нийт 88.84 мян.м³ шимт хөрс хуулж, овоолно.

Хөрс. Хөрсийг экскаватороор хуулж, утгуурт ачигчаар түрэн дотоод овоолго үүсгэх ба нийт хуулж, овоолох хөрсний хэмжээ 176.49 мян.м³ байна.

Жил бүр ашиглалтын үед үүссэн хоосон орон зайг хөрсний дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж хэвгийжүүлнэ.

2.14. Тоног төхөөрөмжүүд

Ил уурхайд хөрс хуулалт болон элс-хайрганы холимог олборлолтын ажлуудад ухаж ачих, тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэнэ. Догол дээр экскаватор ажиллаж, олборлолтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 4. Уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд


Ажлын төрөл	Төрөл	Марк	Үзүүлэлт	Ш/тоо
Олборлолт	Экскаватор	CAT 320C	0.8 м ³	1
	Утгуурт ачигч	XCMG XG955III	3.0 м ³	1
Техникийн нөхөн сэргээлт	Утгуурт ачигч	XCMG XG955III	3.0 м ³	1
Зам услах	Усны машин	Цистерн	27 тн	1

2.15. Ангилан ялгах технологи

Элс хайрга ангилан ялгах технологийн дамжлагад 1 шатны шигшилтийн тоног төхөөрөмжийг ашиглана. Ил уурхайгаас ирсэн элс хайргыг шигшүүрээр ангилан 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм ширхэглэлтэй элс, хайргыг үйлдвэрлэн зах зээлд борлуулна.

Элс-хайрганы холимгийн ангилан ялгах хэсэг нь 04 дүгээр сарын 15-наас 09 дүгээр сарын 15-ны хооронд тасралтгүй ажиллах бөгөөд хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна.

Ангилан ялгах хэсгийн үндсэн тоног төхөөрөмж. Ангилан ялгах хэсгийн тоног төхөөрөмжийн холболтыг доорх зурагт үзүүлэв.



Зураг 2. Бутлан ангилах хэсгийн тоног төхөөрөмжийн холболтын схем

2.16. Гарган авах бүтээгдэхүүн, орлого, зардал

Борлуулалтын орлого. Орд ашиглалтын эхний 5 жилийн хугацаанд нийт 149.49 мян.м³ элс-хайрга борлуулж 2.47 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллана. Нийт орд ашиглалтын хугацаанд 2.46 сая.м³ элс-хайрга борлуулж 40.56 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллана.

Хөрөнгө оруулалт. Ордын уул техникийн нөхцөл, техник тоног төхөөрөмж, үйлдвэрийн хүчин чадал, үйлдвэрлэлийн нөөц зэрэгт үндэслэн шаардлагатай бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн хэрэгцээг тооцон үндсэн хөрөнгийн тоцооллыг хийж гүйцэтгэсэн. Төслийн анхны хөрөнгө оруулалт 502.7 сая төгрөг бөгөөд ашиглалтын хугацаанд нэмэлт хөрөнгө оруулалтын хэмжээ 5.06 тэрбум төгрөг байна.

2.17. Усан хангамж

Төсөл хэрэгжих талбай нь Хэрлэн голын сав газарт багтана. Төслийн үйл ажиллагаанд эхний 5 жилд ашиглах усны хэмжээ 3,376.4 м³, шаардлагатай ундрагын хэмжээ 0.103 л/сек байх ба усны хэрэглээгээ хангах гүний худгийн ундарга 1 л/сек байна.

2.18. Ил уурхайн барилга байгууламжууд

Хүснэгт 5. Барилга, байгууламжийн мэдээлэл

№	Барилгын нэр	Х.нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Уурхайн манаач	м ²	12	1 ш зөөврийн сууц
2	Засварын агуулах	м ²	28.4	40 тн контейнер 1 ш
3	Цайны газар	м ²	28.4	40 тн тохиж.контейнер 1 ш
4	Засварын талбай	м ²	64	Талбайн үржил шимт хөрсийг хуулж, хайрга дайрга асгаж бэлдэнэ

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1. Байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт

Физик газарзүй: “Чойбалсан-1” нэртэй элс-хайрганы холимгийн орд нь Физик газарзүйн мужлалаар Хангайн муж Сэлэнгэ Орхоны савын дундаж өндөр уулс хэсэгт харьяалагдана. Засаг захиргааны хуваариар Дорнод аймгийн Хэрлэн сумын 5-р багийн нутагт харьяалагдах бөгөөд аймгийн төвөөс 2.5 км зайтай.

Газарзүйн байрлал, газрын гадарга: Төслийн талбай нь жижиг толгодорхог рельефтэй Хэрлэн голоо дагасан дунд зэргийн уулархаг толгодорхог гадаргуутай. Тэдгээрийн харьцангуй өндөр нь 25-100 м хооронд хэлбэлзэх бөгөөд хажуу налуугийн өнцөг нь 5-10 градусаас ихгүй. Тэдгээрийн хооронд томоохон хэмжээний тэгшивтэр гадаргуутай талархаг рельефийг үүсгэсэн байна. Үнэмлэхүй өндөр нь 800 м-ээс өндөргүй.

Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын талбайн газрын гадарга нь 745-750 м орчим өргөгдсөн өндөрлөг тэгш тал, Хэрлэн голын хаяа татмын хэсгийг хамран байрших ба ямар нэгэн нам уул, толгод байхгүй юм. Газрын гадаргын хэлбэр дүрсийн хувьд ерөнхийдөө тэгш тал газрын шинжтэй, талын аажуу урсгалтай, өргөн голдрилтой талын голын хэв шинж бүхий Хэрлэн голын татам бүхий тэгш, үл мэдэг хотос, хонхор газар голлоно.

Цаг агаар: Төслийн талбайн ус цаг уур нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд зундаа халуун, өвөлдөө хүйтэн өвлийн үргэлжлэх хэмжээ богино байна.

Жилийн дундаж температур нутгийн хойд болон зүүн хэсгээр 0°C – -2°C , төв ба өмнөд хэсгээр 0°C – $+2^{\circ}\text{C}$ үзүүлэлттэй байна. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур ихэнх нутгаар -20°C , халх голын сав дагуу -25°C бол хамгийн их хүйтэн нь халх голд -47°C хүрсэн байна. харин хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж температур 20°C , хамгийн их халуун 41°C хүрчээ. Тус нутгаар 5°C хавар 4 дүгээр сарын 14-нөөс 5 дугаар сарын 1-ны хооронд дайран дулаарч намар 9 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 13-ны хооронд дайран хүйтэрч нийтдээ 149-182 хоног 5°C - аас дулаан үе үргэлжилдэг байна. Жилд нар гийгүүлэх хугацаа хойд хэсгээр 2700-аас бага цаг, төв ба зүүн хэсгээр 2700-3000 цаг, өмнөд хэсгээр 3000-3200 цаг, зуны нэг өдөр 9-10 цаг, өвлийн нэг өдөр 5-6 цаг байна.

Усан орчин: Голууд нь Хэнтийн нуруу, Их Хянганы уулсаас эх аван Дорнодын тал нутгийг зөвхөн дайран гарч урсдаг бөгөөд тал нутгаар урсахдаа томоохон цутгал голуудыг өөртөө нэгтгэн авах нь ховор, харин усаа ууршуулж ямар нэг хэмжээгээр алддаг байна. Энд нуур нилээд өргөн тархсан байх боловч жижиг хэмжээний нуур зонхилно. Зарим нуурууд гандуу хуурай үед ширгэж хужир, шал тойром болдог.

Дорнод аймгийн нутгаар хэрлэн, халх, улз, дэгээ, нөмрөг, гал, дөч, ямалхай зэрэг гол мөрд, буйр, хөх, яхь нуур болон бусад олон арван жижиг нуур устай. Эмчилгээ сувилгааны ач холбогдол бүхий улсын болон аймаг орон нутгийн зэрэглэлтэй утаат минчүүр, хөх нүдэн, ар булаг, тамсаг булаг, шувуут зэрэг 10 гаруй рашаан, жирмийн цагаан, хулстайн тосон, булан шавар зэрэг 10 орчим эмчилгээний шавартай эрдэст нууруудтай. Эдгээр нь бүгд “нүүрсхүчлийн хүйтэн” рашааны

мужид багтдаг. Гол мөрний үндсэн тэжээл нь зуны хур бороо, гүний ус үлдсэн хэсгийг бүрдүүлдэг. Гол мөрөн, нуурын мөсний горим нь намар 11-р сарын сүүлчээр хөлдөж, хавар 4-р сарын дундуур гэсдэг байна.

Судалгааны талбайн Гидрографын нөхцөл нь Хэрлэн гол ба түүний цутгалангуудаар тэжээгдэх бөгөөд Чойбалсан хотын урдуур урсаж өнгөрдөг. Судалгааны талбайн дундуур өргөрөгийн дагуу урсан өнгөрнө. Голын өргөн 80-100м гүн нь 1,5-2м, урсгалын хурд нь 0,4-0,85м/секундын хооронд хэлбэлзэнэ. ан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Ордын дүүргээр Туул, Бүхэг, Түргэн зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг бөгөөд эдгээр голуудын гольдролын өргөн нь 30-70 м, гүн нь 0.5-1.5 м, урсгалын хурд дунджаар 1.0-1.6 м/сек гэж өмнөх судлаачид тогтоосон байна.

Хөрс: Дорнод аймгийн Хэрлэн сум болон Хэрлэн голын орчмын бүс нутаг нь хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн хөрс-био уур амьсгалын их мужийн Хангайн мужийн Хотгорын бүсшилийн хэв шинж бүхий Баянтүмэнгийн 17-р тойрогт багтана. Баянтүмэнгийн 17-р тойргийн хувьд ухаа толгод бүхий нутгаар сайргархаг, карбонатлаг хар хүрэн, тэгш тал газраар карбонатлаг хүрэн шороон, нам дор хотос болон чийгэрхэг газруудаар нугархаг хүрэн хөрсний хэв шинж зонхилон тархах бол Хэрлэн голын татмын системд аллювийн нугат-намгийн болон алюювийн ширэгт хөрсний шинж тархсан шинжтэй. Төсөл хэрэгжих талбайд талбайн гадаргын хэлбэр дүрстэй уялдан, хүрэн шороон хөрс болон аллювын ширэгт хөрсний хэв шинж тархсан байна.

Ургамал: Төсөл хэрэгжих талбай нь ургамлын хувьд Дорнод Монголын хээрийн тойрогт хамаарна. Дорнод Монголын тал ухаа толгод бүхий харьцангуй өндөрлөг тэгш тал нутагт хамрагдах ба хуурай хээрийн ургамалшилийн хэв шинж зонхилдог. Төслийн талбайд Хиаг улалжит, үетэн алаг өвст, бударгана алаг өвстэй дэрс бүхий нугын ургамлын бүлгэмдэл зонхилно.

Амьтан: Төсөл хэрэгжиж буй нутаг нь газарзүйн мужлалаар Монгол дагуурын тойрогт хамаарна. Төсөл хэрэгжих бүс нутагт дагуур зараа, брандтын багваахай, сахалт багваахай, дагуур огдой, монгол огдой, бор туулай, дагуур зурам, орог зусаг, хээрийн хулгана, саарал чоно, шар үнэг, хярс, цагаан зээр зэрэг амьтад тохиолдоно.

Нийгэм эдийн засгийн үзүүлэлт: Монгол улсын шинэ Үндсэн хуулинд Монгол улсын Засаг захиргааны нэгж аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо байна гэж заасны дагуу 1994 оны 7 дугаар сарын 1-ны өдөр Чойбалсан хот нь Хэрлэн сум болон зохион байгуулагджээ. Чойбалсан хот нь нийслэл Улаанбаатар хотоос 655 км, Хэнтий аймгийн Чингис хотоос 334 км, Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотоос 200 км зайд оршдог. Хойд талаараа Адуунчулууны нүүрсний уурхай, урд талаараа Хэрлэн гол, баруун, зүүн талаараа жижиг гүвээ толгодоор хүрээлэгдсэн 28,0 мян га талбай бүхий нутагтай, уртаашаа 20 км сунаж тогтсон Монгол улсын том зэрэглэлд ордог хот юм. Чойбалсан хот нь Дорнод аймгийн төв бөгөөд Хэрлэн сум нь 10 багтай, 13.2 мянган өрх, 46.2 мянган хүн амтай, нийт хүн амын 48 хувь нь төвлөрсөн хангамжтай орон сууцанд амьдардаг. Эдийн засгийн хувьд төвийн бүсэд багтдаг бөгөөд аж үйлдвэрийн салбар, дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт харьяалагдана. Хэрлэн сум нь Дорнод аймгийн нийт төсвийн орологын 48.1%-г (2020 оны байдлаар) бүрдүүлсэн нь аймагтаа нэгт орж байна.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

4.1. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайн хөрс хуулалт, ачилт, тээвэрлэлт зэргээс ихээхэн хоосон орон зай үүсэх бөгөөд хөрсөн бүрхэвч, ургамал болон шавьжнуудын амьдрах орчинг өөрчилж ховор болон эндемик/унаган/ төрөл зүйлийг багасгах магадлалтай. Үйл ажиллагааны турш тээвэрлэлт явагдах тул талбайн ойр орчмын газрын гадаргыг тоос дарж хөрс, ургамал, орчныг бохирдуулна.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл байна.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайн зам усалгаа болон унд-ахуйн усны хэрэгцээг гүний худгаас авч ашиглах бөгөөд энэ нь газрын доорх усны хомсдолд үүсгэж болзошгүй.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс болон ургамлыг бохирдуулна. Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүснэ. Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулж болзошгүй.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Ил уурхайн талбайд байсан ургамал устана. Уурхайд олон янзын зориулалтаар машин техник ашиглаж, тэдгээрээс үүдэн олон салаа зам үүсч бий болох магадлалтай. Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадаргад шороо тоос үүсч, улмаар салхи шуурганд хийсэн ойр орчмын ургамал бүрхэвч, төслийн талбай тоос шороонд дарагдаж болзошгүй. Ахуйн хог хаягдал их хэмжээгээр үүсч, хадгалах зайлуулах стандарт, дүрэм, журам барьж ажиллаагүйгээс гадаргад бохирдол үүсч болзошгүй. Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадарга болон ургамлан нөмрөгт бохирдол үүснэ. Тоосжилт үүссэнээс ойр орчмын ургамлууд дээр бууж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно. Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдахаар байна.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Олборлолт явуулсны улмаас хөрс хуулж овоолго хийгээд орхисон байгаа ба овоолго болон түүний орчмын талбайн амьтан /элдэв шавжийн бүлгэмдэл/ тэдгээрийн амьдрах орчин үгүй болох.

Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Ажилчдын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж чадна. Уурхайн

ажлын үед ажиллах хүнд машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүснэ.

Хогийн цэгээс үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл: Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадаргад бохирдол үүснэ. Хэдийгээр дунд хугацаанд нөлөөлөл үзүүлэх боловч төслийн хугацаа дуусахад эргэн нөхөн сэргээгдэх боломжтой.

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“СҮХЖИН” ХХК-ийн “ЧОЙБАЛСАН-1” элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“ЧОЙБАЛСАН-1” элс-хайрганы холимгийн ордыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 11,108.0 мян.төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг зэрэгт төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно,
- БОМТ-ий дагуу үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг тодорхойлох,
- Мэргэжлийн байгаль орчны ажилтантай байх,
- БОМТ-ий тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийг цаг тухай бүрт холбогдох байгууллагуудад хүргүүлэх, тайлагнах, хүлээлгэн өгөх шаардлагатай.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ,

дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

“Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг, / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	-Уурхайн үйл ажиллагааны үед үүсэх тоосжилт, -Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, -Тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа хий, тортог, гарах, -Хог хаягдлыг ил задгай асгаснаас орчны эвгүй үнэр үүсэх.	Уурхайн тээвэрлэлтийн зам, уурхай орчимд тоосжилт дарах усалгааг тогтмол хийх	Уурхайн талбай, тээвэрлэлтийн зам	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	Тогтмол	-2010 MNS 4585:2007. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, -MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга.
2		Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх	Тээврийн хэрэгсэл	-	80,000	4 ш	320,000	Жил бүр	
Газрын хэвлий, хөрсөн бүрхэвч									
1	-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс газрын гадарга, хөрс	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулахгүй байх, олон салаа зам гаргахгүй байх.	Тээврийн хэрэгсэл	-	-	-	-	Тогтмол	-MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,

2	элэгдэл эвдрэлд өртөх, -ШТМ асгарч газрын гадарга хөрсийг бохирдуулах.	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах, шаардлагатай багаж материалыг бэлэн байлгах.	ШТМ	-	-	-	1,000,000	Тухай бүрт	-MNS 4006:1987 Хөрс. MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. -MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
Гадаргын ба газрын доорх усны нөөц									
1	-Бохир усыг ил задгай асгаснаас үүдэн орчны бохирдол үүсэх.	Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх.	-	-	-	-	-	Тогтмол	-Усны тухай хууль, -MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, -MNS 900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт.
2		Ундны усны шинжилгээг тогтмол өгч байх.	-	-	-	ОХШХөтөлбөрт тусгасан	Жил бүр		
Нийт зардал							1,320,000		

6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нөхөн сэргээлт хийх	Овоолго байдлаар хадгалсан шимт хөрсөөр өөрдсийн олборлосон талбайд нөхөн дүүргэлт хийнэ.	0.2 га талбайд	-	-	4,000,000	2026 онд	- MNS 5916:2008, Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт

								MNS 5917:2008, Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Нийт зардал						4,000,000		

6.3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутагтай хамтарч ажиллах, дүйцүүлэн хамгаалах ажил хийх санал орон нутгаас авах, хэрэгжүүлэх.	Орон нутгаас санал авсны үндсэн дээр эвдэрч, эзэнгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх ажлыг гүйцэтгэх.	-	-	-	3,000,000	2026 онд	-Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх гарын авлага, -БОНБНУ-ий тухай хууль.
2	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	2025 онд тарьсан бургасыг арчлан хамгаалах, услаж тордох.	Арчлан хамгаалах	-	-	300,000	2026 онд	
Нийт зардал						3,300,000		

6.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбайн ойр орчмын бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө хийгдэхгүй болно.

6.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбайн ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна. Хэрэв уурхайн эдэлбэр газарт түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд нэн даруй дүүрэг, хорооны захиргаанд болон мэргэжлийн байгуулагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай.

6.6.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Гэнэтийн осол аваар гарах, -Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, -Галын гэнэтийн аюул үүсэх.	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, багаж хэрэгслийг нэмэгдүүлэх, сайжруулах	Уурхайн кемп орчимд	-	-	1,500,000	2026 онд	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, -Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17).
2		Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж ажиллах	“Сүхжин” ХХК	-	-	-	Жил бүр	
3		Ажилд гарахын өмнө ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Уурхайн удирдлага	-	-	-	Тогтмол	
4		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангах (өлмийний хамгаалалттай түрийтэй гутал, хамгаалалтын нүдний шил, дуулга, тоосны маск, ажлын бээлий гэх мэт)	Уурхайн ажилчид	14	-	Үйл ажиллагааны зардалд орсон	Жил бүр	
Нийт зардал						1,500,000		

6.7.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2026 он/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хатуу болон шингэн, аюултай хог хаягдлаас үүдэн уурхайн орчин бохирдох.	“Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-тэй хог тээвэрлэлтийн гэрээг шинэчлэн байгуулж, хог хаягдлыг тухай бүрт тээвэрлүүлэх.	Хог хаягдал	-	100,000	-	100,000	Жил бүр	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/, -MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага.
2		Хог хаягдлын төвлөрсөн түр цэгийг суурийг хөрсөнд нэвчихээргүй хатуу хучилттай болгох, цементлэх.	Хог хаягдлын цэг	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2026 онд	
3		Ашигласан шатах, тослох материалыг зориулалтын савыг нэмэгдүүлэх, уурхайн орчинд асгарч алдагдахаас тухай бүр сэргийлэх, ШТМ-ыг дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх	ШТМ-ыг поошкинд дүүрсэн үед тээвэрлүүлэх.	-	-	-	-	2026 онд	
Нийт зардал							100,000		

6.8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт “Чойбалсан-1” элс хайрганы холимгийн ордыг олборлохоор “СҮХЖИН” ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа болон үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөлөх байдлын үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг / 2026 он /	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын орчин							
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	- Тээвэрлэлтийн замаас, -Ил уурхай орчмоос	Жилд 1 удаа	Агаарын сорьц дээж 45,000	120,000	Дорнод аймгийн цаг уур орчны шинжилгээний харъяа лабораторит	- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,
Хөрсөн бүрхэвч							
1	Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	-Ил уурхай орчим, -Кемп орчим	Жилд 2 удаа	28,000	112,000	Итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3985: 87. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл -MNS 3310:91. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох.
2	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co, Cu)	-Тээвэрлэлтийн зам.	Жилд 2 удаа	28,000	56,000		
Усан орчин							

1	Усны химийн шинжилгээ (рН, ЕС, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Унд ахуйн уснаас	Жилд 2 удаа	50,000	100,000	Усны итгэмжлэгдсэн лаборатори	-MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ, -MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага, - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус- химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх, -MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга,
Нийт зардал					388,000		

6.9.Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв / 2026 он /	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 онд				
			6-р сар	7-р сар	8-р сар		
1	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	500,000		+		Уурхайн удирдлага	Ажилчдад аюулгүй ажилларгааны зааварчилгааг тогтмол өгч байх.
2	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны зардалд орсон		+		Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.
3	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох		+		Уурхайн удирдлага	Байгаль орчны төлөвлөгөөт аудит 2 жил тутамд хийлгэх

4	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай тохиролцох		+		Уурхайн удирдлага	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэх
5	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний дагуу хамтран ажиллах, орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан нягт хамтран ажиллах
Нийт зардал		500,000					

6.10.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.

Хүснэгт 12. БОМТ-ийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	Дорнод аймгийн Хэрлэн сумын 5-р багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-нд өгөх санал, зөвлөмж	11-р сар	Дотоод төлөвлөлтөөр	“Сүхжин” ХХК-ийн удирдлага	Дорнод аймаг, Хэрлэн сум, 5-р баг
2	Дорнод аймгийн БОАЖГ, БОУАӨЯ	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг хянуулан батлуулах	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	11-р сар	Дотоод төлөвлөлтөөр	“Сүхжин” ХХК-ийн удирдлага	Дорнод аймгийн БОАЖГ, БОУАӨЯ

6.11.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2026 он /төгрөг /
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,320,000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	4,000,000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3,300,000.0
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсэдлийн менежментийн төлөвлөгөө	1,500,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	100,000.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500,000.0
9	БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	388,000.0
Нийт		11,108,000.0

“СҮХЖИН” ХХК-ний “ЧОЙБАЛСАН-1” элс-хайрганы холимгийн ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **11,108,000** төгрөгийг зарцуулахаар төлөвлөлөө.

ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “СҮХЖИН” ХХК-ийн “Чойбалсан-1” элс хайрганы холимгийн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаа явуулах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан дараах дүгнэлтэнд хүрлээ.

“СҮХЖИН” ХХК-ийн 2026 оны БОМТ-ний тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

“СҮХЖИН” ХХК нь 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээнүүдийг тухай бүрт хэрэгжүүлж тухайн онд хийсэн ажлаа холбогдох газруудаар хянуулж батлуулах шаардлагатай байна.

“Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордын 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ **11,108,000.0** (Арван нэгэн сая нэг зуун найман мянга) төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

“СҮХЖИН” ХХК нь 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 31-р зүйлд заасны дагуу БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болох болно.

Мөн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 1-р улиралд багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан ажиллах шаардлагатай.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Журам шинэчлэн батлах тухай Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын А-36 тоот тушаал, 2011 оны 2 дугаар сарын 16, 1-р хавсралт
4. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
6. Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших ДО-001А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ, 2021 он
7. Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2022 он
8. Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Чойбалсан-1” элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглах төслийн БОМТ, 2025 он
9. <http://www.legalinfo.mn//>